НИЙСЛЭЛИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ХЯНАЛТАД АВСАН ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 24 Улаанбаатар хот

| Шийдвэрийн дэс дугаар | Зүйл, заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Шийдвэрийн холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Биелэлтийн хувь | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ** | | | | | | |
| 1 | 1 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 | 55.3.Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах 2024 оны хөтөлбөрт 2 бүлэг, 13 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилтийг хангуулан ажиллав. Үүнд:<br>- Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд 18 сургалт, семинарт нийт 80 албан хаагчийг хамруулсан.<br>- Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран нэгдсэн эмнэлгийн салбар эрүүл мэндийн 13 дугаар төвд нийт албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан.<br>- Хөдөлмөрийн дотоод журмын дагуу 9 албан хаагчид 2,5 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олгосон.<br>- Хяналтын улсын байцаагчийн эрх олгуулах, цуцлуулах саналыг Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, холбогдох сайдын эрх олгосон тушаалыг үндэслэн улсын ахлах байцаагчаар 4, улсын байцаагчаар 1, нийт 5 албан хаагчийг албан тушаалд нь жинхлэн томилсон.<br>- Төрийн жинхэнэ албаны болзол, шаардлага хангасан 27 албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдлийг шинээр болон ахиулан олгуулах саналыг Төрийн албаны | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай” А/369 дүгээр захирамжаар албан хаагчдын зэргийн нэмэгдлийг олгуулсан. | | |
| 2 | 2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай 2023-05-04 | 10.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг Ёс зүйн хороо, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, томилох эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбогдуулан гаргасан иргэн, хуулийн этгээдийн гомдол мэдээллийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үүрэг бүхий байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог газрын даргын 2024 оны А/46 дугаар тушаалаар байгуулсан. | 100% | - |
| | 3 | | 13.1.Ёс зүйн дэд хороо нь байгууллагын албан хаагчийн тооноос хамааран 3-7 гишүүнтэй байх бөгөөд гишүүд дотроосоо даргаа сонгоно. | Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнийг 2024 оны 9 дүгээр сард газрын нийт албан хаагчдаас нууцаар санал хурааж 7 гишүүнтэй байгуулав. | 100% | - |
| 3 | 4 | Төрийн хяналт шалгалтын тухай хууль 2003-01-03 | 9.1.Хяналт шалгалтын байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>9.1.1.хуульд заасны дагуу хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандартын биелэлтэд хяналт тавих; | Барилга, дэд бүтцийн салбарын 25 хууль, 186 журам, тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, 480 гаруй техникийн зохицуулалт, 1500 гаруй стандартын биелэлтэд хяналт тавих хүрээнд 21 хяналтын улсын байцаагч ажиллаж, 2024 онд давхардсан тоогоор 4600 гаруй иргэн аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж ажилласан байна. | 100% | - |
| | 5 | | 9.1.2.хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх; | - Барилга, дэд бүтцийн салбар чиглэлээр салбарын хяналтын http://shilenkhyanalt.gov.mn цахим системд нийт 269 объектын эрсдэлийн үнэлгээг оруулж, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 79 дүгээр тогтоолоор баталсан “Салбарын хяналт шалгалтын төлөвлөгөө”-ний дагуу их, | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 197 объектод хяналт шалгалтыг зохион байгуулав.<br>- Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтцийн салбарын хяналтын нэгдсэн цахим системийг бий болгож, үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан. Уг ажлын эхний үе шат буюу хяналт шалгалтын объектын бүртгэл хөтлөх, мэдээллийн сан үүсгэх гар утасны аппликейшн нэвтрүүлэх, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. | | |
| | 6 | | 9.1.5.хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн акт, техникийн зохицуулалт, стандарт, тэдгээрийг үндэслэн төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг хэрхэн хэрэгжүүлж байгааг судлан нэгтгэж, холбогдох хууль тогтоомж, шийдвэрийг боловсронгуй болгох саналаа төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх; | Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор батлагдсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 7 заалт бүхий санал, "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах жишиг зардлыг тооцох тухай" Барилга, хот байгуулалтын сайдын тушаалын төсөл зэргийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/135 дугаар албан бичгээр Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. | 100% | - |
| 4 | 7 | "Барилгын тухай хууль"<br>2016-02-05 | 35.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга барилгын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:<br>35.1.1.нутаг дэвсгэртээ барилгын салбарт баримтлах төрийн бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавих; | Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм"-ийг баримтлан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. 2024 онд барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах нийт 1592 хүсэлт ирүүлснээс гүйцэтгэл дутуу, баримт бичгийн бүрдлийг хангуулаагүй, баримт бичгийн зөрчилтэй, эрчим хүчний барилга байгууламж хамгаалалтын зурвас зэхникийн үзүүлэлт шаардлага хангаагүй 460 хүсэлтийг татгалзаж шийдвэрлэсэн. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | 8 | | 35.1.2.барилгын үйл ажиллагаанд барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг мөрдүүлэх; | Барилга, хот байгуулалтын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 43 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Их эрсдэлтэй үнэлэгдсэн 4 аж ахуйн нэгжид 35.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, бага эрсдэлтэй үнэлэгдсэн 39 аж ахуйн нэгжид улсын ахлах байцаагчийн зөвлөмж хүргүүлсэн. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 1283 өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, 100.0 сая төгрөгийн торгууль тавьж, албан шаардлага хүргүүлж, 6 зөвлөмжийг 150 ААНБ-д хүргүүлсэн. | 100% | - |
| | 9 | | 35.1.5.барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам батлах, хэрэгжилтийг хангах; | Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар батлагдсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны Үлгэрчилсэн журам”-ын дагуу нийслэлийн хэмжээнд барилгын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд мөрдөх “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт хүргүүлэв. | 90% | - |
| | 10 | | 35.1.6.Энэ хуулийн 32.1.5, 33.1.23-т зааснаас бусад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах; | Нийслэлийн нутаг дэвсгэрт улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламж, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын захиалгаар шинээр баригдсан бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламж, барилга байгууламжийн гадна цахилгаан хангамж, засвар, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг 1217 байршилд зохион байгуулж, комиссын нийт гишүүдийн санал, дүгнэлтээр 853 ажлыг хүлээн авч, 364 ажлыг татгалзах шийдвэр гарган ажилласан байна. | 100% | - |
| | 11 | | 35.1.7.барилга байгууламжийн баримт бичгийн шаардлагад нийцээгүй барилга байгууламжийг улсын хяналт хэрэгжүүлэгч байгууллагын | 2024 онд баримт бичгийн шаардлагад нийцээгүй 5 барилгад улсын байцаагчийн дүгнэлт гарган 3 байршилд Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр барилгыг буулгуулж, 2 дүгнэлт шүүхийн шатанд хэлэлцэгдэж байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ерөнхий байцаагчийн дүгнэлт болон шүүхийн шийдвэрийг үндэслэн албадан буулгах арга хэмжээг авч, холбогдох зардлыг буруутай этгээдээр төлүүлэх; | | | |
| **Хэсгийн дундаж хувь: 99%** | | | | | | |
| **ХОЁР. УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ** | | | | | | |
| 5 | 12 | Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай 2024-04-18 Дугаар 2024_27 | 2. 2.Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа, арга хэмжээг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8, 6.9 дэх хэсэгт заасны дагуу үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Ёс зүйн хороо, Засгийн газрын, төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороо, бүх шатны томилох эрх бүхий албан тушаалтанд тус тус даалгасугай. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог Хяналт шалгалтын азрын даргын 2024 оны А/46 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэд хорооны үйл ажиллагааг сурталчлан таниулах ажлын төлөвлөгөөг баталж дараах ажлыг хэрэгжүүлэн ажиллав. Үүнд<br>- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны А/109 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г албан хаагчдад танилцуулж мэдээлэл хүргэв.<br>- Төрийн албан хаагчдын ёс зүй, ёс зүйн тухайн хууль болон холбогдох хууль, ёс зүйн хэмжээний талаарх мэдээлэл сургалтыг нийт албан хаагчдад 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.<br>- "Үндсэн хууль ба тэгш эрх" сэдвээр соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг нийт албан хаагчдад 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр зохион байгуулав.<br>- Байгууллагын албан хаагчдын ёс зүй, зан харилцааны талаар санал асуулга явуулж, "Ёс зүйтэй албан хаагч"-ийг шалгаруулсан.<br>- Албан хаагчдаас 3 гомдол, мэдээлэл хүлээн авч, тухайн ёс зүйн зөрчилд холбогдуулан 2 албан хаагчид сахилгын арга хэмжээ авах тухай шийдвэрийг газрын удирдлагад танилцуулан хариуцлага тооцов. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | |
| **ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ** | | | | | | |
| 6 | 13 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 46 | 3. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхүүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | -Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр байгууллагын нэрийн тэмдэг, мэдээллийн самбарын бичвэрийг монгол, кирилл бичгээр хослуулан бичиж байршуулсан.<br>-“Монгол бичгийн үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Хэл Иргэншлийн Эрдмийн Хүрээлэнтэй хамтран төрийн албан хаагчдад зориулсан Монгол бичгийн дунд шатны сургалтад тус газрын 10 албан хаагч хамрагдаж гэрчилгээ гардан авсан. | 90% | |
| **Хэсгийн дундаж хувь: 90%** | | | | | | |
| **ДӨРӨВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ** | | | | | | |
| 7 | 14 | Орон сууцны хороолол, цогцолбор барилгад хүүхдийн цэцэрлэг байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2022.11.09 Дугаар 402 | 1.2. байнгын ашиглалтад хүлээн авсан орон сууцны хороолол, цогцолборын хэмжээнд барилгын норм, дүрмийн шаардлага хангасан цэцэрлэг төлөвлөгдөн баригдсан эсэхэд үзлэг хийж, дүнг танилцуулахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазарт; | Төрийн хяналт шалгалтын хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтийн 12 хотхон хороололд шалгалт хийснээс төлөвлөгдсөн зураг төслийн дагуу сургууль цэцэрлэг барьсан 2, сургууль цэцэрлэг барихаар газар чөлөөлсөн 7, газар чөлөөлөхөөр бэлтгэл ажлыг хангуулж буй 1, баригдаж буй орон сууцны барилгын 1 дүгээр давхарт цэцэрлэгийг төлөвлөсөн 2 хотхон байна. Төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгарсан байгууллага нь бусад байгууллагуудад төслийн талбарыг гэрээний үндсэн дээр шилжүүлж төслийг хуваан хэрэгжүүлснээр сургууль, цэцэрлэгийн барилга баригдахгүй үлдэх нөхцөл бүрдэх эрсдэлтэй байна. | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах чиг үүргийн хүрээнд батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу орон сууцны -хороололд баригдсан:<br>- Хан-уул дүүргийн 23 дугаар хороо, 250 ортой 2 барилга;<br>- Хан-Уул дүүргийн 16 дугаар хороо, 240 1 барилга;<br>- Сонгинохайрхан дүүрэг, 34 дүгээр хороо, 100 ортой 1 барилга;<br>- Сонгинхайрхан дүүрэг, 1 дүгээр хороо, 100 ортой 1 барилга;<br>- Баянзүрх дүүргийн 13 дугаар хороонд 480 суудалтай 1 барилга;<br>- Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороонд 640 суудалтай 1 барилга.<br>Нийт 940 ортой 5 цэцэрлэг, 1120 суудалтай 2 сургуулийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж, дүгнэлтийг баталгаажуулж ажилласан. | | |
| | 15 | | 1.3. цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолбор барилгын зураг төслийг баталж магадлан хийсэн, барилгын ажлын зөвшөөрөл олгосон, хүлээн авч ашиглалтад оруулсан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцуулах талаар зохих арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм"-ийг баримтлан Барилга байгууламжийг ашиглалтад оруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж байна. Батлагдсан зургийн дагуу цэцэрлэгийн барилга төлөвлөөгүй орон сууцны хороолол, цогцолборын барилгыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулаагүй болно. | 70% | |
| 8 | 16 | 2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай | 3. Авилгатай тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, бүх талын дэмжлэг | Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулж батлуулсан. Байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023-02-08 Дугаар 49 | үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. | хэрэгжилтийг 2024 оны хагас бүтэн жилийн байдлаар нэгтгэн гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичгээр хүргүүлсэн. Мөн Авлигатай тэмцэх газраас авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн мэдээ мэдээллийг байгууллагын мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулан иргэд олон нийтэд тухай бүр мэдээллийг хүргэн ажиллав. | | |
| 9 | 17 | Нийслэл Улаанбаатар хотод гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, нийслэлийн хот төлөвлөлт, газар зохион байгуулалттай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2023-08-16 Дугаар 294 | 1.5.барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, автозам, зогсоол, дугуйн зам, явган хүний зам, гарц, зэрэг нийтийн эзэмшлийн зам, талбай, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн эзэмшлийн газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, зохих зөвшөөрөл, төлөвлөлтгүйгээр эзэмшүүлж, ашиглуулсан, барилга байгууламж барьсан асуудлыг судалж, хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулж, хууль зөрчиж зөвшөөрөл өгсөн байгууллага, албан тушаалтнаас учруулсан хохирлыг нэхэмжлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | - Нийслэлийн хэмжээнд нийтийн эзэмшлийн газрыг зориулалтын дагуу ашиглаагүй, зохих зөвшөөрөл, төлөвлөлтгүйгээр эзэмшүүлж, ашиглуулсан, барилга байгууламж барьсан асуудлаар дараах 4 байршилд хяналт шалгалт зохион байгуулж холбогдогч талуудад албан бичгээр мэдэгдэл хүргүүлэн барилгын ажлыг зогсоосон. Үүнд:<br>➢ ХУД, Мөнхсан ХХК;<br>➢ БЗД, Хан талст ХХК;<br>➢ СБД, Мөргөл-Уул ХХК;<br>➢ СБД, иргэн Г.Баттүшиг.<br>Тодруулбал Нийслэлийн Засаг даргын захирамжаар Мөнхсан ХХК-ийн архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг түр түдгэлзүүлж, Мөргөл-Уул ХХК болон иргэн Г.Баттүшигийн газар эзэмших эрхийг тус тус цуцлуулав.<br>- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй барилга угсралтын ажил эхлүүлсэн, барьсан 220 зөрчил илрүүлж, 13 иргэн, хуулийн этгээдэд зөрчлийн хэрэг нээж, 197 иргэн, хуулийн этгээдэд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 10 хэргээс татгалзаж, зөрчилд нийт 541.7 сая төгрөгийн мөнгөн торгууль ногдуулж, зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлж ажилласан. | 90% | - |
| **Хэсгийн дундаж хувь: 82.5** | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| **ТАВ. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ** | | | | | | |
| 10 | 18 | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах тухай<br><br>2022.09.28 Дугаар_47 | IX.1.6. “Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”-д заасан хүн ам, барилгажилтын тооцоот нягтралын хязгаарыг давсан байршилд зөвшөөрөл олгосон барилгын ажлын хуульд заасан норм, шаардлага, стандартыг хангуулах, хэрэгжилтийн явцыг 2022 оны 10 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн хэмжээнд хүн амын нягтаршил хэтэрсэн 47 нэгж талбар байна. Дараах 17 байршилд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын хүрээнд хяналт шалгалт хийж, төлөвлөгдсөн, орц гарцгүй, хот төлөвлөлтийн норм дүрэм зөрчсөн барилгад дүгнэлт гаргаж, шаардлага бүхий аж ахуй нэгж байгууллагын газар эзэмших эрхийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар цуцлан, барилга угсралтын ажлыг зогсоосон. Үүнд:<br>1. Хан-Уул дүүргийн 15-р хороо, Төв цэнгэлдэх хүрээлэн орчмын нягтаршил ихтэй бүс;<br>2. Сүхбаатар дүүргийн 8-р хороонд нягтаршил ихтэй байршил;<br>3. Баянзүрх дүүргийн 16-р хороо иргэн Ч.Оргилын захиалгатай барилга;<br>4. Баянзүрх дүүргийн 26-р хороо, иргэн Т.Дүүрэнгийн үйлчилгээ, конторын зориулалттай газар 6 давхар үйлчилгээний барилга;<br>5. Баянзүрх дүүргийн 26-р хороо, Мандала хотхоны урд 3 давхар орон сууцны барилга;<br>6. Хан-Уул дүүргийн 16-р хороо, “Эй энд Ти Эм” ХХК-д олгосон 16 давхар орон сууцны барилга;<br>7. Сүхбаатар дүүргийн 1-р хороо Эрүүл мэндийн яамны захиалгаар гүйцэтгэж байгаа барилга;<br>8. Хан-Уул дүүргийн 3-р хороо, Эм Си Жи Си ХХК-ийн захиалгатай 13 давхар үйлчилгээтэй орон сууцны барилга угсралтын ажил;<br>9. Хан-Уул дүүргийн 3-р хороо, иргэн Б.Баясгалангийн захиалгатай 16 давхар орон сууцны барилга;<br>10. Хан-Уул дүүргийн 20-р хороо Вольф групп ХХК-ийн захиалгатай 7 давхар оффис үйлчилгээний барилга угсралтын ажил; | 70% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | 11. Баянзүрх дүүргийн 6-р хорооны Наран трейд ХХК-ийн захиалгатай ажилчдын 16 давхар орон сууц 1 блок, 2 давхар спорт заал;<br>12. Баянзүрх дүүргийн 6-р хороо, Бөхийн өргөөний баруун урд байрлах Ти Энд Эйч трейд ХХК болон иргэн Н.Ганбаатар нарын захиалгатай үйлчилгээ бүхий орон сууцны зориулалттай 12 давхар 2 блок барилга;<br>13. Баянзүрх дүүргийн 43-р хороо, Нарны зам дагуу байрлах Миний сүлжээ-125 салбар дэлгүүрийн ар талд иргэн А.Эрмүүний захиалгатай барилга;<br>14. Сүхбаатар дүүргийн Сүхбаатар дүүргийн 8-р хороо, Монголын гимнастикийн холбооны ард иргэн В.Баяржаргалын захиалгатай үйлчилгээний барилга;<br>15. Сүхбаатар дүүргийн 9, 11-р хороо, Арга билиг цамхаг ХХК, Силикат ХХК, Пинктовер ХХК-иудын гэр хорооллын дахин төлөвлөлтийн талбай;<br>16. Сүхбаатар дүүргийн 11-р хороонд "Мөнх ариун булаг" ХХК-ийн үйлчилгээтэй орон сууцны барилга;<br>17. Сүхбаатар дүүргийн 11-р хороонд "Наранбулаг трейд" ХХК-ийн 16 давхар 152 айлын орон сууцны барилга. | | |
| 11 | 19 | УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхэд барилгын салбарт үүссэн зарим хүндрэлтэй асуудлууд 2024.01.17 Дугаар_03 | 15.1. 2021 оны 11 дүгээр сараас 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор зөвшөөрөлгүй баригдсан барилга байгууламжийн үе шатны зөвшөөрлийг мөрдөгдөж байгаа норм, дүрэмд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоосон мэргэжлийн байгууллага, ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн барилгын ажлын зөвшөөрөл болон үе шатны баримт бичгийг нэг удаа нөхөн олгох боломжийг | Барилга, Хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024 оны 35/А/163 дугаартай хамтарсан тушаал, захирамжаар энэхүү асуудлыг судлах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу Хот байгуулалт хөгжлийн газар, Хотын стандарт хяналтын газар хамтран зөрчилтэй барилгын судалгааг нэгтгэн гаргасан. Нийт 108 иргэн, аж ахуйн нэгжийн 210 блок барилга байгууламжийн судалгааг нэгтгэн ажлын хэсэгт танилцуулахаар 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/274 дугаартай албан бичгээр Барилга хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. Одоогоор ямар нэгэн шийдвэр гараагүй болно. Дээрх | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хууль тогтоомжийн хүрээнд судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар нарт тус тус даалгав | барилга байгууламжтай холбоотой асуудлаар нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хандахыг иргэд, хуулийн этгээдүүдэд зөвлөсөн. | | |
| 12 | 20 | Боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлж байгаа зарим төсөл, арга хэмжээний явцыг эрчимжүүлж авах арга хэмжээний талаар 2024.05.15 Дугаар_19 | 3.Хот байгуулалтын норм, стандартын дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилга барих зориулалтаар газар чөлөөлөх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль бариагүй орон сууцны хотхон, хорооллыг ашиглалтад хүлээн авахгүй байх, ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны газраас төлөөлөл оруулж, хяналтыг сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав | - Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулан ажиллахдаа Хот байгуулалт, хотын стандартын газраас баталсан төлөвлөлт, барилгын ажлын зөвшөөрлийн дагуу байнгын ашиглалтад хүлээн авдаг.<br>Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын жишиг бүрэлдэхүүнд нийцүүлэн Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжаар комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлуулсан.<br>- Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн барилгыг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд нийслэлийн Боловсролын газрын төлөөлөл тогтмол оролцон ажиллаж байна.<br>- Тайлант хугацаанд Нийслэлийн боловсролын газрын Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн Д.Ирмүүнзаяа нийт 21 (цэцэрлэг-13, ерөнхий боловсролын сургууль-8) барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд оролцсон байна. | 20% | - |
| **Хэсгийн дундаж хувь: 63.3%** | | | | | | |
| **ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОЛОН ЕРӨНХИЙ САЙДЫН АЛБАН ДААЛГАВАР** | | | | | | |
| 13 | 21 | 2024 оны эхний хагас жилд | 4.7.Нийслэлийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн арга хэмжээг | Гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтийг эрчимжүүлэх төсөл, арга хэмжээний тухай 2024-01-12 Дугаар 2024_01 | зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарт; | хүсэлтийн дагуу ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулж нийт 46 аж ахуй нэгж байгууллагын хүсэлтээр ирүүлсэн 52 блок, 5911 айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан. Үүнд:<br>- Баянзүрх дүүрэгт 25 блок (2816 айл)<br>- Хан-Уул дүүрэгт 4 блок (403 айл)<br>- Баянгол дүүрэгт 4 блок (720 айл)<br>- Сонгинохайрхан дүүрэгт 4 блок (384)<br>- Сүхбаатар дүүрэгт 15 блок (1588 айл) | | |
| 14 | 22 | “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023.04.17 Дугаар 01 | 1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт. | Нийслэлийн хэмжээнд ашиглалтад орсон бага, дунд, өндөр төвөгшилтэй ангиллын 180 барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг холбогдох маягт, зааврын дагуу нэгтгэн боловсруулж Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Нийслэлийн Статистикийн газарт тус тус хүргүүлсэн. | 100% | - |
| **Хэсгийн дундаж хувь: 100%** | | | | | | |
| **ЗУРГАА. МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЗӨВЛӨМЖ** | | | | | | |
| 15 | 23 | Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулах тухай 2024.07.25 Дугаар 01/37 | Барилга, нийтийн эзэмшлийн зам талбай, орчны горм, дүрэм, стандартыг мөрдүүлж, зөрчлийг шуурхай таслан зогсоох хариуцлага тооцох | Хяналт шалгалтын газар нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг барилга, дэд бүтцийн салбарын мэргэжлийн 13 чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, холбогдох журмын дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус (өргөдөл гомдол), урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад дараах арга хэмжээг авч ажиллав. Үүнд: | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | - Хууль тогтоомж, норм ба дүрэм, стандарт зөрчсөн, зөвшөөрөлгүй барилга байгууламжийн угсралтын ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэсэн нийт 86 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 319.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчил дутагдлыг арилгуулах тухай эрх бүхий албан тушаалтны даалгавар хүргүүлж, гүйцэтгэл 80 гаруй хувьтай байна.<br>- Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд барилга угсралтын шатанд гарч буй зөрчил дутагдлыг нэгдсэн байдлаар арилгуулах, орчны аюулгүй байдлыг хангуулах зорилгоор төвийн 6 дүүргийн хэмжээнд барилга угсралтын ажил гүйцэтгэж буй нийт 227 иргэн, ААНБ-уудын үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 442 зөрчил дутагдал илрүүлж, 158 шаардах хуудас, 16 мэдэгдэх хуудас, 16 улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага хүргүүлж, 35 иргэн, хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж зөрчлийг арилгуулж ажиллав.<br>- Нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн ашиглалт, угсралтын үйл ажиллагааг хариуцан ажиллаж буй нийт 17 аж ахуйн нэгж байгууллагад мэдэгдэл хүргүүлж, ил задгай холболттой нийт 399 гэрэлтүүлгийн шонг бүрэн тагжуулж, 27 хазайсан шонг тэгшлүүлж, гэрэлтүүлгийн шон хооронд унжсан 4370 метр сип кабелийг цэгцэлж, эзэн холбогдогч нь тодорхойгүй газарт унжсан, авто замын гэрэлтүүлгийн шонг дамнуулан зөвшөөрөлгүй татсан 2376 метр шилэн кабель буулгуулав. | | |
| | 24 | | Сургууль, цэцэрлэг, дотуур байрны гадаад болон дотоод орчны аюулгүй байдалд тавигдах стандартын шаардлагад нийцэж | - Эрчим хүчний яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан "Төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай" 11/02 дугаартай удирдамжийн дагуу нийслэлийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн гадна | 90% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийх, шинээр баригдах барилга, өргөтгөл, шинэчлэлтийн ажилд хууль тогтоомж, норм, норматив, стандартын шаардлагыг хангуулах арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх | болон дотор цахилгаан, дулаан хангамжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын төлөв байдал, аюулгүй ажиллагаанд хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 8 сургууль, 12 цэцэрлэгийг хамруулж, эрчим хүчний хяналтын улсын (ахлах) байцаагчийн хамтарсан 20 зөвлөмж, 20 дүгнэлтийг тус тус хүргүүлэн гүйцэтгэлд хяналт тавьж 4 сургууль, 5 цэцэрлэгийн шугам сүлжээнд засвар үйлчилгээ хийлгүүлэв.<br>- Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02-13-01/023/03 дугаартай "Улс нийслэлийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй барилга байгууламж, орчны аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд сургууль, цэцэрлэгийн барилгын ажил гүйцэтгэж буй 12 төсөл арга хэмжээнд хяналт шалгалт хийж, барилга угсралт, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангуулах тухай улсын ахлах байцагчийн зөвлөмжийн хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна. | | |
| | 25 | | Орон сууц, гэр хороолол, сургууль, цэцэрлэг, эмнэлэг, худалдаа, үйлчилгээний барилгын зэргэлдээ орших галын аюулгүй байдлын зай хэмжээг зөрчсөн шатахуун түгээх станц болон авто хий цэнэглэх станцуудын судалгааг гаргаж, нүүлгэн шилжүүлэх, аюулгүй байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах | Шатахуун түгээх станцаас зэргэлдээ орших барилга, байгууламж хүртэл хамгийн бага зайг "Шатахуун түгээх станц. Галын аюулгүйн норм БНбД 21-07-14"-д 25 метр, хатуу түлшээр галладаг байрнаас 50 метр байна гэж заасан. Хамгийн бага зайд тавигдах шаардлагад сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага, ерөнхий боловсролын сургууль, сургуулийн дотуур байр, хэвтэн эмчлүүлдэг эмчилгээний байгууллагуудын эдэлбэр газрын хилээс хэмжинэ гэж нормчилсон байдаг.<br>Нийслэлийн хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, түгээлт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг 41 аж ахуйн нэгжийн 284 шатахуун түгээх станц, 56 АХЦС (автомашин хийгээр цэнэглэх станц)-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийснээс дээрх норм дүрэмд заасан зай хэмжээний зөрчилтэй 39 ШТС, АХЦС байна. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Үүнээс сургууль орчмын 3, гэр хороололд 1, орон сууц, олон нийтийн барилга орчимд 35 байна. АХЦС-ууд ил сав ашиглаж байгаа нь хий алдагдсан тохиолдолд галын аюул осол үүсэх эрсдэлтэй бөгөөд аюулгүй зай хэмжээ зөрчиж хүүхдийн цэцэрлэг, худалдаа үйлчилгээний барилгатай ойр баригдсан байна. Дээрх хяналт шалгалтын танилцуулга, цаашид авах арга хэмжээний саналыг Улсын онцгой комисст хүргүүлэв. | | |
| | 26 | | Хууль тогтоомж, норм, норматив, стандартын шаардлага хангахгүй явган хүний замыг үе шаттайгаар шинэчлэх, нийтийн эзэмшлийн талбай, явган хүний замыг хааж зөвшөөрөлгүй барилга байгууламжийг хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авах | Хяналт шалгалтын газрын даргын 2024 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 02-13-01/023/01 дугаартай удирдамжийн хүрээнд нийтийн эзэмшлийн зам талбайд хууль, тогтоомж, норм дүрэм, стандарт зөрчсөн барилгын хийцлэл, өргөтгөл, эзэн холбогдогч нь тодорхойгүй контейнер, түц, гарааш зэрэг нийтийн эзэмшилд шилжүүлэх шаардлагатай нийт 38 байршлын судалгааг гаргаж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах талаар нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд 2024.06.27-ны өдрийн 01/302 дугаартай албан бичиг хүргүүлэв. | 100% | - |
| | 27 | | Цаашид эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангуулах ажлын хүрээнл барилгын ажлын аюулгүй ажиллагааны журмын төслийг боловсруулан баталж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллах | Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 195 дугаар тушаалаар “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны үлгэрчилсэн журам”-ыг баталсан. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5-д заасны дагуу дээрх үлгэрчилсэн журмын хүрээнд “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ын төслийг мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудаас санал авч нэгтгэн боловсруулж, 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 01/787 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газарт хүргүүлсэн. | 90% | Батлагдаа-гүй тул хяналтад үлдээх. |
| **Хэсгийн дундаж хувь: 96%** | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| **ДОЛОО. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ** | | | | | | |
| 16 | 28 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.01.18 А/64 | Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Ар гүнд, 24-р хороо Баруун салаа, 34-р хороо Баянголын ам, 42-р хороо Зүүн салаа, Баянзүрх дүүргийн 11-р хороо Хонхор, 20-р хороо Энгэр шанд, Арцат Хуандай амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зургийн даалгаврыг боловсруулахад тусгуулах санал, зөвлөмжийг тус газрын 2024 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/78 дугаартай албан бичгээр Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. Мөн Хот байгуулалт, хөгжлийн газарт зохион байгуулагдсан зургийн даалгаврыг хэлэлцүүлэх хуралдаанд оролцож, санал хүргүүлсэн. | 100% | Хяналтаас хасуулах. |
| 17 | 29 | Иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2024.01.18 А/91 | 1. Нийслэлийн хэмжээнд иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг нийслэлийн нутгийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай. 1.1. харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх<br>1.2. өргөдөл гомдлыг бүртгэж, шилжүүлэх үйл явцын зөрчлийг арилгах, шат дамжлага, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай | Нийслэлийн Хяналт шалгалтын газарт 2024 онд нийт 2313 өргөдөл, гомдол, хүсэлт, зөрчил, санал бүртгэгдэж ирсэн бөгөөд үүнээс судлагдаж байгаа 111, хугацаанда шийдвэрлэсэн 2161. Харъяалалын дагуу шилжин ирсэн өргөдөл, гомдол хүсэлтийг шийдвэрлэх дундаж хугацаа нь /2201 өргөдлийг 19 хоног 10 цаг 38 минут/-д шийдвэрлэсэн бөгөөд 2023 оны мөн үетэй /1964 өргөдлийг 18 хоног 13 цаг 0 минутад шийдвэрлэсэн/ харьцуулбал хугацааны хувьд 5.2 хувиар өссөн. 2024 оны нийт ирсэн өргөдөл, гомдол нь 2023 оны мөн үетэй харьцуулахад 11.5 хувиар өссөн байна.<br>Өргөдөл, гомдлыг байгууллагын чиг үүргийн дагуух хүсэлтийг бүртгэн шилжүүлэн ажилласан. Тус газарт саналын ангилалаар нийт 23 санал бүртгэгдсэн бөгөөд үүнээс саналын шинжтэй 2 асуудлыг авч үзэн судлахад байгууллагын үйл ажиллагаанд тусгах боломжтойгоор шийдвэрлэсэн байна.<br>Удаа дараа ирүүлж буй иргэдийн өргөдөл, гомдлыг тухайн албан тушаалтанд шилжүүлэхгүйгээр дотоод хяналт шинжилгээний хэлтэст шилжүүлэн шалгуулан арга хэмжээ авч ажилласан. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж ажиллах;<br>1.3. саналын шинжтэй өргөдлийг судалж, түүнийг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар хуулийн хугацаанд, зохих хэлбэрээр хариуг иргэнд заавал өгч, энэ тухай мэдээллийг өргөдөл, гомдлын мэдээнд тусгайлан оруулж хэвших;<br>1.4. гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлэхгүй байх;<br>1.5. иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож, сахилга, хариуцлагыг чангатгах; | Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй-41. Өргөдөл, гомдлыг хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 9 албан хаагчдад байгууллагын дотоод журмын дагуу арга хэмжээг авч ажилласан.<br>Мөн өргөдөл, гомдлын цахим систем болох ERP системийн доголдлоос үүдэн хугацаа хэтэрсэн мөн өргөдөл, гомдол хариуцсан ажилтан солигдсоноос үүдэн хяналт суларсан зэргээс хугацаа хэтрэлтийн тоо нэмэгдсэн.<br>Шийдвэрлэлтийн явцад ёс зүйн зөрчил гаргасан гомдол бүртгэгдээгүй болно.<br>Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 7 хоног бүрийн өргөдөл гомдлын тоо мэдээг 32 удаа, 1 дүгээр улирал, хагас жил, 3 дугаар улирлын тайлангуудыг хүргүүлэн ажиллав. | | |
| | | | 2. Иргэдийн гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэх, гомдол гархад нөлөөлж байгаа эрсдэл, хүчин зүйлийн үнэлгээг сүүлийн 3 жилийн мэдээлэлд үндэслэн эрх зүйн орчин, төсөв санхүү, хүний нөөц, байгууллагын үйл ажиллагааны удирдлага зохион | Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, хуулийн хугацаанд бүрэн барагдуулж шийдвэрлэх, хариуг иргэнд заавал өгч хэвших, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр нөлөөлж байгаа хүчин зүйлс, тэдгээрт эрсдэлийн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулагдан ажиллаа. Тус ажлын хэсэг нь 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хуралдан байгууллагын | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулалт, салбар хороодын уялдаа холбооны түвшинд нарийвчлан гаргаж, түүний дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээний саналаа НЗДТГ-т 2024.02.05-ны дотор ирүүлэх | хэмжээнд сүүлийн 3 жилийн хугацаанд ирсэн өргөдөл гомдлын бүртгэл мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээг хийж, ажлын хэсгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, НЗДТГ-ын Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд 02 дугаар сарын 19-ний өдөр 02/159 дугаар албан бичгээр хүргүүлэв. | | |
| 18 | 30 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.02.01 А/107 | Нийслэлийн хэмжээнд ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөн барилгажуулах болон гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах | Хот байгуулалт хөгжлийн газраас ирүүлсэн хөндлөнгийн байгууллагын судалгааны дүгнэлтийг үндэслэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 7 барилгад улсын ахлах байцаагчийн дүгнэлт гаргаж Хот байгуулалт хөгжлийн газарт, мөн 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 01/375 дугаартай албан бичгийг Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн. | 100% | - |
| 19 | 31 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.02.07 А/146 | Богдхан Уулын тусгай хамгаалалтын газар, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын нийслэл хотын албан татвар, газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл мэдээллийг тулган баталгаажуулах, бүртгэх, албан татварын ногдол, төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэх, шинээр өмчлөгч эзэмшигчийг бүртгэх, дэлгэрэнгүй судалгаа мэдээллээр ханган хамтран ажиллаж албан татварын хуулийн хэрэгжилтийг хангуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах | Ажлын хэсгийн хуралд 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр оролцсон. Ажлын хэсэг 2024 оны 02 дугаар сарын 26-аас 05 дугаар сарын 13-ны хүртэл ажиллах ба дээрх хугацаанд 140 тэрбум төгрөгийн төсвийг төвлөрүүлэхтэй холбоотойгоор манай байгууллагын зүгээс батлагдсан төлөвлөгөөний дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт 2020-2023 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээлэл, судалгааг боловсруулах маягт батлагдаж ирүүлэхээр хүлээгдэж байна. | 50% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 20 | 32 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.02.09 А/157 | Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем “UB ENGINEERING”-ийг 2024.05.01-ний өдрийн дотор ашиглалтад оруулах, холбогдох журам боловсруулах | Ажлын хэсгийн 3 удаагийн уулзалтын хүрээнд өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем "UB-ENGINEERING"-д барилга байгууламжийн комиссын орон зай, талбарын мэдээлэл болон цаашид хөгжүүлэлт хийх 4 санал боловсруулж, төслийн дэд ажлын хэсэгт орж ажиллах албан хаагчдын нэрсийг 2024 оны 2 дугаар сарын 26-ний өдөр 02/206 тоот албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн. | 100% | - |
| 21 | 33 | Үерийн хариу арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2024.02.20 А/174 | 2. Үерийн хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, шуурхай, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг нийт нутгийн захиргааны байгууллагын дарга, удирдлага, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай /Төлөвлөгөөний 43-т "Үерийн эрсдэлтэй бүсэд суурьшсан иргэдэд албан шаардлага хүргүүлэх"/ | - Иргэд, аж ахуйн нэгжүүд далан сувагт ил задгай хог хаягдал их хэмжээгээр хаяснаас хогны цэг үүссэн, далан сувгийн хамгаалалтын зурвас газарт газар эзэмших барилга барих, үйлчилгээ эрхлэх зэрэг зөрчил дутагдлууд арилгуулах тухай улсын байцаагчийн 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 02-13-02/041/04 дугаартай зөвлөмжийг дүүргүүдийн Засаг дарга нарт хүргүүлсэн.<br>- Шар усны үер болон Уруйн усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 2024.03.15-ны өдрийн 02-013-02/041/11 дугаартай 6 заалт бүхий зөвлөмжийг Нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нарт хүргүүлэв.<br>- Болзошгүй үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, үүсэж буй зөрчлийг арилгуулах чиглэлээр олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон байгууллагын албан ёсны веб хуудас, пейж хуудсаар тогтмол анхааруулга зөвлөмж мэдээлэл хүргэн ажиллаж байна. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |
| 22 | 34 | Захиргааны актыг түр түдгэлзүүлэх тухай 2024.03.26 А/309 | 1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 15-р хороо Төв цэнгэлдэх хүрээлэнгийн орчмын газар олголт, ашиглалт, барилгажилтын төлөв байдал, нягтаршлыг тодорхойлж, цаашид өсөн нэмэгдэх нягтаршлыг бууруулах, Төв цэнгэлдэх | Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, Төв цэнгэлдэх хүрээлэн орчмын нягтаршлыг бууруулах тухай асуудлаар Мөнх сан ХХК-д олгогдсон 4, 10, 24 давхар бүхий үйлчилгээ, оффис, зочид буудлын барилгын төлөвлөлт, холбогдох баримт бичигт хяналт шалгалт хийж, барилга угсралтын үйл ажиллагааг түр зогсоосон. Хяналт шалгалтаар зөрчил илрээгүй тул 2024 оны 08 дугаар | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | хүрээлэнгийн ашиглалтын хэвийн ажиллагааг хангуулах, иргэдийн эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх зорилгоор Нийслэлийн Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалт, хөгжлийн газрын 2020.07.03-ны өдрийн ГБМЗХ2020/29-007 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зургийг түр түдгэлзүүлсүгэй.<br>2. Барилга угсралтын үйл ажиллагааг түр зогсоохыг ХСХГ-т үүрэг болгосугуй | сарын 13-ны өдрийн А/998 дугаар захирамжаар А/309 дүгээр захирамжийг хүчингүй болгосон. | | |
| 23 | 35 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.03.26 А/310 | Сонгинохайрхан дүүргийн 25 дугаар хорооны иргэн О.Одсүрэнгээс ирүүлсэн Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсангийн аманд Олд консракшн ХХК-ийн гүйцэтгэж, хууль тогтоомж зөрчин орших суух зориулалтаар ашигласан гэх гомдлын дагуу хяналт шалгалтыг зохион байнуулж, гомдлыг эцэслэн шийдвэрлэх | Тухайн барилга байгууламжид компанийн төлөөллийг байлцуулан 2024 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр газар дээр нь үзлэг шалгалт хийж, баримт бичгийг татан авч хяналт шалгалтыг хийж, Олд констракшн ХХК-д холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, Зөрчлийн тухай хуулийн 12.1 зүйлийн 1.11 дэх заалтын дагуу зөрчилд торгуулийн арга хэмжээг авч, эрх бүхий албан тушаалтны хугацаатай албан даалгавар хүргүүлж, эрх бүхий албан тушаалтны албан даалгаврыг биелүүлээгүй үндэслэлээр тус газрын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн 01/145 дугаартай албан бичгээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан биелүүлэх захирамж, гүйцэтгэх хуудас гаргуулахаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлсэн. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 24 | 36 | Төслийн хэрэгжилтийг хангуулах тухай 2024.04.26 А/461 | Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-тэй холбогдуулан иргэдийн зорчилт хөдөлгөөний суурь судалгаа, зураг төслийг боловсруулахад шаардагдах төсвийн тооцооллыг хийж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх арга хэмжээ авах үүрэг бүхий Ажлын хэсэг | Тус ажлын хэсэгт газрын дарга гишүүнээр ажиллаж байна. /Төслийн эхний шугам болох “Яармаг, Арцат – Өнөр хороолол” чиглэлийн барилгын газар шорооны ажил 2024 оны дөрөвдүгээр сард эхэлсэн бөгөөд нарийвчилсан зураг төслийг Барилгын хөгжлийн төвийн Зөвлөлүүдийн хурлаар хэлэлцүүлэн, магадлах ажил хийгдэж байна. Төслийн гүйцэтгэгч “Пома” группийн Франц улсад үйлдвэрлэсэн эд ангийн материалууд 11 болон 12 дугаар сард төслийн талбай дээр амжилттай хүргэгдэж ирсэн. Хоёрдугаар шугам болох “Үндэсний соёл, амралтын хүрээлэн - Үндэсний цэцэрлэгт хүрээлэн” чиглэлийн трасс зураг гараад байна. https://ulaanbaatar.mn/news/20415 / | 100% | ДБСХХ |
| 25 | 37 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.04.30 А/479 | “Туул усан цогцолбор” төслийн техник, эдийн засгийн үндэслэл, хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хамтран хэрэгжүүлэх санал, дүгнэлт боловсруулах | Ажлын хэсгийн хуралдаанд Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч (усан хангамж, ариутгах татуурга) Б.Тэмүүлэн оролцсон. "Туул усан цогцолбор" төслийн хүрээнд 2024 оны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд манай газрын чиг үүргийг хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ тусгагдаагүй байна. | 100% | Хяналтаас хасуулах |
| 26 | 38 | Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай 2024.05.03 А/503 | 2. Барилга байгууламж болон барилга байгуууламжийн гадна талбайн тохижилт, засварлах тоноглох ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, стандарт шаардлагад нийцүүлэн зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Хяналт шалгалтын газарт (С.Төмөрдулам)-т даалгасугай | Нийслэлийн хэмжээнд шинээр баригдсан бага, дунд, өндөр төвөгшилтэй барилга байгууламж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн барилга байгууламжийг ашиглалтад оруулах нийт 1592 хүсэлт ирүүлснээс 460 хүсэлтийг татгалзаж, 1273 хүсэлтийг комиссын хуваарьт оруулан ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг зохион байгуулав. Үүнд:<br>• Барилга байгууламж - 392<br>• Эрчим хүчний барилга байгууламж - 652<br>• Засвар тохижилтын ажил – 229. | 100% | - |
| 27 | 39 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.05.21 А/584 | 1.“Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” болон “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”- | Ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцсон. Тус газраас Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөлд 2 зорилтын 5 төсөл, арга хэмжээний санал боловсруулж 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/126 дугаар | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | ний төслийг боловсруулах үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг 1 дүгээр, Ажлын хэсэгт мэргэжил арга зүй, техникийн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар тус тус байгуулсугай. | албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” батлагдаж, тус газрын үндсэн хэрэгжүүлэх-1, хамтран хэрэгжүүлэх-4 арга хэмжээ батлагдсан.<br>“Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн төсөлд тусгах саналыг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 01/772 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 24/08 дугаар тогтоолоор “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлагдаж, тус газрын үндсэн хэрэгжүүлэх 3 зорилт тусгагдсан. Хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд 11 арга хэмжээний санал боловсруулж 2024 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/1070 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | | |
| 28 | 40 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.06.10 А/677 | Болзошгүй үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баянзүрх дүүргийн 21, 27 дугаар хорооны нутаг дэвсгэр, Дарь-Эхийн орчимд Сэлбэ голын үерийн далангийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, эрсдэлтэй бүсээс айл өрхийг нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлөх, шилжин суурьших бүсийн амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн | Геодези усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ-иай хамтран 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс 03 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргүүдийн шар усны үер болох эрсдэлтэй Сэлбэ гол дагуу далан сувгуудад хяналт шалгалт хийж гүйцэтгэж, танилцуулгыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | бүрэлдэхүүнийг хавсралтаар батлсугай. | | | |
| 29 | 41 | Хяналтын хороог шинэчлэн байгуулах тухай 2024.06.12 А/691 | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хэрэгжилтэд хяналт тавих, төслийн хэрэгжилттэй холбоотой гомдол, саналыг хэлэлцэх, нөхөх олговрын хэмжээг тогтоох зорилгоор үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хяналтын хороог хавсралт ёсоор шинэчлэн байгуулсугай. | Тус хяналтын хорооны бүрэлдэхүүнд Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтэс Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч (хот төлөвлөлт) З.Ганбат ажиллаж байна. Хяналтын хороо 2 удаа хуралдаж холбогдох санал дүгнэлтийг хүргүүлж ажилласан. | 100% | - |
| 30 | 42 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.06.19 А/720 | Улаанбаатар хотын Шинэ тойрог авто замын трассыг шинэчлэх, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төслийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг хийж гүйцэтгэх, ажлын даалгавар боловсруулах | Ажлын хэсгийн 3 удаагийн хуралд гишүүнээр орж, 3 санал дэвшүүлсэн. Үүнд:<br>- Явган хүний замын өргөнийг хамгийн багадаа 2 метрээр төлөвлөх, хөдөлгөөний эрчим ихтэй гудамжинд хамгийн багадаа 4.5 метрээр төлөвлөх.<br>- Огцом эргэлттэй хэсгүүдэд аюулгүй гэрэлтүүлгийн систем тусгах.<br>- Аюулгүйн харилцаа холбооны хэрэгслийг байршуулах (SOS). | 100% | - |
| 31 | 43 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.06.24 А/754 | Метро барьж байгуулах төслийн зөвлөх үйлчилгээний тендерт оролцогч шалгарсан тул дээрх гэрээг байгуулахад мэргэжил, арга зүйгээр хангах, санал боловсруулах | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/1083 дугаартай захирамжаар батлагдсан ажлын хэсгийн хуралд оролцож зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод холбогдох саналыг тусгуулан ажилласан. Ажлын хэсгийн 2 дахь хурал 09 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. | 100% | ДБСХХ |
| 32 | 44 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.07.09 А/853 | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, зогсоолын хүртээмжийг нэмэгдүүлэх | Нийт 8 удаагийн хуралд оролцож хөтөлбөрийн төсөл боловсруулахад 3, авто зогсоол ашиглах журмын төсөлд 2 саналыг дэвшүүлж ажилласан. | 100% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | зорилгоор "Зогсоол нэгдсэн хөтөлбөр"-ийг боловсруулах | | | |
| 33 | 45 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.08.07 А/949 | Улаанбаатар хотын Шинэ тойрог зам төслийн Туулын авто зам, гүүрэн байгууламж болон Нисэхийн хурдны замыг Туулын авто замтай холбох авто замыг барьж байгуулах ажлыг дотоод болон гадаадын хуулийн этгээдийг нээлттэй оролцуулах замаар төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах, шаардлагатай бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлт гаргах | Ажлын хэсгийн 8 удаагийн хуралд гишүүнээр оролцсон. | 100% | ДБСХХ |
| 34 | 46 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.08.26 А/1022 | Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийг зөрчсөн зөрчлийг газар дээр нь шуурхай арилгах ажлыг зохион байгуулах | Ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар Барилга байгууламж ашиглалт бүртгэлийн хэлтсийн дарга О.Оджаргал ажиллан 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр ажлын хэсгийн хуралдааныг зохион байгуулж, 22 байгууллагын 24 төлөөлөл оролцов. Дүүрэг тус дэд ажлын хэсэг байгуулж захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажилласан. Захирамжийн биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| 35 | 47 | Захирамжийн хавсралтад өөрчлөлт оруулалт тухай 2024.08.27 А/1026 | Нийслэлийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/96 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн зөвлөмж, оршин суугч иргэдийн санал хүсэлтийн дагуу “Түймэрт өртсөн 207 дугаар байрыг сэргээн засварлах ажил (Улаанбаатар хот, Бачнзүрх дүүрэг, 26 дугаар хороо)” төсөл, арга хэмжээний ажлын даалгавар боловсруулах | Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Эдү апартмент хотхоны 207 дугаар байрны ашиглалтын байдалд хяналт шалгалт хийж, Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтийг гарган газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн шийдвэрээр ашиглалтыг хориглож, шийдвэрийг 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 01/845 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт тус тус хүргүүлсэн. | 100% | - |
| 36 | 48 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.08.29 А/1043 | "МУЗГ, Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын корпораци хооронд байгуулсан Мянганы сорилтын компакт гэрээний “Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаа”-ны дагуу хэрэгжиж байгаа “Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн хэрэгжилтийг хангахад хэрэглэгчдийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, төлбөр тооцооны цогц цахим систем хөгжүүлэх, системийг хэрэглээнд ашиглахтай холбоотой журмын төслийг боловсруулж, батлуулах | Улсын Их Хурлын даргын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 79 дүгээр захирамжаар байгуулагдсан "Ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангагдах эрхийн хэрэгжилттэй танилцаж, санал, дүгнэлт гаргах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал боловсруулан танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэгт тус газрын Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Б.Тэмүүлэн оролцож 5 саналыг тусгуулж ажилласан. | 100% | - |
| 37 | 49 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.08.30 | Хотын стандартын хэлэлцүүлэг зохион байгуулж, хянан | Гуравдугаар ээлжинд батлуулах хотын стандартын төслийг иргэд, олон нийтэд хэлэлцүүлэх хэлэлцүүлэг 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан | 100% | Бүрэн хэрэгжсэн, |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | А/1044 | тохиолдуулах эрх бүхий байгууллагаар батлуулах | бөгөөд хотын стандартын төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барих 19 хотын стандартын төслийг хянан тохиолдуулах ажлын хэсгийн хуралд Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн дарга Б.Найрамдал оролцон стандартын төсөлд тухайлсан саналыг тусгуулж ажилласан. | | хяналтаас хасуулах |
| 38 | 50 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.09.30 А/1137 | Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ төрлийн багтаамж ихтэй нийтийн тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилгоор “Нисэхийн тойрог уулзвараас Сансарын аюулгүйн тойрог уулзвар хүртэлх авто замын дагуу тусгай замын автобус зорчих хэсгийн инженерийн дэд бүтцийн урьдчилсан судалгаа”-г боловсруулах үүрэг бүхий | Улаанбаатар хотын зорчилт хөдөлгөөнийг сайжруулах техникийн туслалцаа буюу Нийслэлийн нийтийн тээвэрт тусгай замын автобус (BRT) нэвтрүүлэх төсөлд 3 санал боловсруулж, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/369 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. | 100% | - |
| 39 | 51 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.11.28 А/1394 | Кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны журам боловсруулах | Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн хэлтсийн дарга О.Оджаргал гишүүнээр томилогдсон. Одоогоор тус ажлын хэсгийн хурал зарлагдаагүй байна. | - | - |
| 40 | 52 | Ажлын хэсэг байгуулах тухай 2024.12.04 А/1459 | Хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох санал, зөвлөмж боловсруулах | Тус ажлын хэсэг нь 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдөр хуралдсан бөгөөд Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох 5 хууль тогтоомжийн 15 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг хуулийн төсөл, зөвлөмжийн хамт боловсруулсан ба Ажлын хэсгийн ахлагч Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан Нэгдүгээр орлогч Т.Даваадалайд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна. | 70% | - |
| **Хэсгийн дундаж хувь: 96.6%** | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| ЕС. НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ | | | | | | |
| 41 | 53 | Хотын хөгжлийн индексийн үзүүлэлт батлах тухай НЗД-ын 2023 оны А/1024 дүгээр захирамжийн хэрэгжилт, Хотын хөгжлийн индексийг тооцох судалгааны ажил 2024.01.09 Дугаар 01 | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газрууд байгууллагын веб сайтаа шинэчилж баяжуулах, англи хэл дээр хувилбартай болгон 7 хоног бүр мэдээллээ шинэчилж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Л.Хосбаяр)-т, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, харьяа газруудын удирдлагуудад тус тус үүрэг болгов | Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийг өөрчлөн зохион байгуулах тухай" А/430 дугаар захирамжаар тус газрын бүтэц, чиг үүрэг, нэр өөрчлөгдсөнтэй холбоотойгоор вебсайтыг www.inspection.ub.gov.mn домэйн нэрд шилжүүлэх хүсэлт хүргүүлж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр "Үндэсний дата төв" УТҮГ-тай байгууллагын цахим шуудан, домэйн нэр олгох, мэдээллийн аюулгүй байдлын хяналттай холбоотой үйлчилгээний гэрээг байгуулж веб хуудасны хөгжүүлэлтийг хийж байна. | 70% | - |
| 42 | 54 | Нийслэлийн нутаг дэвсгэрт баригдсан барилга байгууламж, барилгын их засвар, шинэчлэлтийн ажлыг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаа 2023.12.26 20 дугаар хуралдаан | 1. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/861 дүгээр "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" захирамжийг шинэчлэн батлуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т үүрэг болгов | •2024 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж чиг үүрэг байгууллагад шилжин ирж буйтай холбоотой захирамжийн шинэчилсэн төслийг боловсруулж Нийслэлийн Засаг даргын нэгдүгээр орлогчид танилцуулсан.<br>• Захирамжийн шинэчилсэн төслийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 захирамжаар шинэчлэн батлуулсан. | 100% | - |
| | 55 | | 2. Барилгын гадна фасадыг цаг уурын онцлог /эрс тэс уур амьсгалтай хот/-т тохируулж барилгын чанар стандартад нийцсэн ачаалал даахуйц материал ашиглах талаар боломжийг судалж танилцуулах | Барилгын фасад болон дулаалгын материалын хэрэглээ өнөөгийн байдлын судалгааг гарган Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 03 дугаар 25-ны өдрийн 06 дугаар хуралд хэлэлцүүлж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсны дараа холбогдох шийдвэрийг гаргуулахаар хяналт шалгалтын ажлыг хийж хууль, тогтоом, норм стандартын шаардлагыг хангуулж ажилласан. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | 56 | | 3. Барилгын гадна фасадны материал үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, материалын эрэлт нийлүүлэлтийг зохицуулах талаар судалгаа хийж, 2024 оноос эхлэн барилгын гадна фасадад барилгын дулаалгын хөөс, бусад материал ашиглуулахгүй байхыг зураг төсөлд тусгуулах, мөрдүүлж ажиллахыг ХБХГ, ХСХГ | Нийслэлийн хэмжээнд хөөсөн полистрол хавтан үйлдвэрлэгч 84 аж ахуйн нэгж байгууллагуудын дунд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан 5 саналыг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын архитекторуудын эвлэлээр уламжлуулан 1500 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл хүргүүлж ажилласан. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |
| | 57 | | 5. Хяналт шалгалтаар илэрсэн хууль журмын хүрээнд хэрэгжилтийг хангуулах боломжгүй 10-аас дээш жил удаан хугацаанд зогссон барилга байгууламжуудын талаар мэдээллийг бэлтгэж цаашид авах арга хэмжээний санал танилцуулахыг ХБХГ, ХСХГ-т | Нийслэлийн хэмжээнд орчны бохирдол үүсгэсэн, газар шорооны ажил дутуу хийгдэж удаан хугацаанд зогссон ухсан нүхтэй, овоолсон шороотой, эвдэрч нурсан хашаатай, олон жил барилга угсралтын ажил зогссон 75 байршлын судалгааг гарган Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлж, хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. | 100% | - |
| | 58 | | 6. Нийслэлийн өмчид бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийн судалгааг гарган, буулгаж нийтийн эзэмшлийн зам талбай болгох асуудлыг судалж, буулгах ажлыг зохион байгуулахыг НӨХГ, ГЗБА, ХСХГ, ХБХГ-т | 2024 онд Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас нийслэлийн өмчид бүртгэлтэй ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилга байгууламжид улсын /ахлах/ байцаагчдын дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй. | - | Хяналтад үлдээх |
| 43 | 59 | 2023 онд хийсэн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх танилцуулга | 5. Барилга, дэд бүтцийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж танилцуулах | Хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор "Барилга, дэд бүтцийн болон бусад хяналтын салбарын хяналт, шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр" боловсруулах ажлын хэсгийг газрын даргын 2024 оны А/30 дугаар тушаалаар байгуулж, хөтөлбөрийн хүрээнд 5 зорилт, 16 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төслийг | 90% | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2023.12.26 20 дугаар хуралдаан | | боловсруулсан. Хөтөлбөрийн төслийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр саналыг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 01/1005 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлж, хөтөлбөрийн танилцуулга, зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн төслийн “Хяналтын дагалдах хуудас”-т зөвлөлийн гишүүдээр хянуулж, санал авч байна. | | |
| 44 | 60 | Барилгын гадна фасадын чанар стандарт, ашиглалтын өнөөгийн байдал 2024.03.25 06 дугаар хуралдаан | 1. Нийслэлийн хэмжээнд хөөсөн полистрол хавтан үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллагуудад урьдчилан сэргийлэх хамтарсан хянал шалгалт хийж, үр дүн, гүйцэтгэлийг тооцож ажиллахыг ХСХГ, НОБГ | Барилга, хот байгуулалтын сайдын 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 87 дугаар тушаал, 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 96 дугаар тушаалаар баталсан “Импортоор орж ирсэн цементэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамж, Газрын даргын баталсан 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02-13-01/023/08 дугаартай удирдамжийн хүрээнд нийслэлийн хэмжээнд арматур импортлогч, үйлдвэрлэгч 15 аж ахуйн нэгж, барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал /хөөсөн полистрол хавтан/ үйлдвэрлэгч 48 аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийсэн. Барилгын үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлгүй, тохирлын гэрчилгээгүй 13 аж ахуйн нэгж, байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 60.0 сая төгрөгийн торгууль ногдуулж, гүйцэтгэлийг хангуулах ЭБАТ-ны зөрчил арилгуулах тухай албан даалгавар хүргүүлэв. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |
| | 61 | | 3. Холбогдох зураг төсөлд хяналт тавих чиг үүргийн байгууллагуудад санал боловсруулж, хүргүүлэхийг ХБХГ, ХСХГ-т | Нийслэлийн Засаг даргаас өгсөн үүргийн дагуу нийслэлийн хэмжээнд хөөсөн полистрол хавтан үйлдвэрлэгч 84 аж ахуйн нэгж байгууллагуудын дунд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгийн үр дүнд гарсан дараах саналыг холбогдох байгууллагуудад 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 01/955 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан. Үүнд:<br>1. Барилгын тухай хуулийн төсөлд барилгын материал үйлдвэрлэгч, импортлогч иргэн, аж ахуйн нэгжүүдийн | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | чиг үүрэг, харилцааг тодорхой болгосон зохицуулалт нэмэх;<br>2. Барилга байгууламжийн зураг төсөлд барилгын дулаан тусгаарлах материал, гадна фасадны материалын стандартын үзүүлэлтүүдийг холбогдох норм дүрэмд тодорхой тусгах;<br>3. Гамшиг судлалын хүрээлэнгийн мөрдөж буй ГОСТ стандартын галд тэсвэржилтийн зэргийг тодорхойлох, стандартыг шинэчлэх;<br>4. Барилгын дулаан хамгаалалтын төлөвлөлт БД 23-103-10-ын 7.15 дугаар заалт "Хашлага бүтээцэд шатамхай дулаалга хэрэглэсэн үед цонх ба бусад нээлхийний периметрээр 80-90 кг/м3 багагүй нягттай шатдаггүй эрдэс хөвөн дулаалгаар 200 мм-ээс багагүй өргөнтэй зурвасаар хүрээлж өгнө."-ыг холбогдох барилгын норм ба дүрэмд тусгаж өгөх.<br>5. Барилгын гадна фасадны чанар стандартад нийцээгүй материал , түүхий эд ашигласан, хэрэглэсэн зөрчилд хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, зөрчлийг дахин үйлдүүлэхгүй хариуцлагажуулах зорилгоор Барилгын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах. | | |
| | 62 | | 4. Нийслэлийн хэмжээнд барилгын гадна фасад, дулаан тусгаарлах материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, байгууллагын дунд 2024 оны 04 дүгээх сарын 15-22-ны өдрийн хооронд хэлэлцүүлэг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн | Нийслэлийн хэмжээнд хөөсөн полистрол хавтан үйлдвэрлэгч 84 аж ахуйн нэгж байгууллагуудын дунд 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг Барилгын хөгжлийн төв ТӨҮГ, Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбоо, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбоо, Монголын архитекторуудын эвлэлээр уламжлуулан 1500 гаруй аж ахуйн нэгж байгууллагуудад мэдээлэл хүргүүлж ажилласан. | 100% | Бүрэн хэрэгжсэн, хяналтаас хасуулах |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | | асуудал хариуцсан орлогч П.Сайнзориг, ХБХГ, ХСХГ, НОБГ, НОСБГ, НХОГ-т | | | |
| 45 | 63 | Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсөл, явган хүний замын ажлын явц 2024.08.27 12 дугаар хуралдаан | 4. Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлтийн ажлын бүх үе шатанд захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, тэмдэг тэмдэглэгээ, орчны аюулгүй байдал, иргэдийн зорчих хөдөлгөөнд садаа болох зэрэг нөхцөл байдал үүсгэхгүй байхыг Нийслэлийн Замын хөгжлийн газар (Г.Баярсайхан), Нийслэлийн Хяналт шалгалтын газар (С.Төмөрдулам), Улаанбаатар зам засвар, арчлалтын газар (Б.Галхүү)-т; | Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй 15 авто зам, замын байгууламжийн угсралт, шинэчлэлтийн ажилд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, 35 заалт бүхий 8 албан шаардлага, 6 заалт бүхий 2 дүгнэлт, 8 заалт бүхий 1 акт, 1 зөрчлийн хэрэг нээж 10.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан. | 100% | - |
| **Хэсгийн дундаж хувь: 96%** | | | | | | |

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (төрлөөр)

| Д/д | Шийдвэрийн төрөл | Шийдвэрийн тоо | Хэрэгжилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | "Бүрэн хэрэгжсэн" 100% (90-100 хувь) | "Хэрэгжих шатанд" 70% (50-90 хувь) | "Хэрэгжилт хангалтгүй" 30% (10-50 хувь) | "Хэрэгжээгүй" 0% (0-10 хувь) | "Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" | |
| 1 | Монгол Улсын хууль | **4** | **11** | 11 | - | - | - | - | 99% |
| 2 | Улсын Их Хурлын тогтоол | **1** | **1** | 1 | - | - | - | - | 100% |
| 3 | Ерөнхийлөгчийн зарлиг | **1** | **1** | 1 | - | - | - | - | 90% |
| 4 | Засгийн газрын тогтоол | **3** | **4** | 2 | 2 | - | - | - | 82.5% |
| 5 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | **3** | **3** | 1 | 1 | 1 | - | - | 63.3% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Засгийн газрын болон Ерөнхий сайдын албан даалгавар | **2** | **2** | 2 | - | - | - | - | 100% |
| 7 | Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын зөвлөмж | **1** | **5** | 5 | - | - | - | - | 96% |
| 8 | Нийслэлийн Засаг даргын захирамж | **25** | **25** | 22 | 1 | 1 | - | 1 | 96.6% |
| 9 | Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл | **5** | **11** | 9 | 1 | - | 1 | - | 96% |
| **Нийт:** | | **45** | **63** | 54 | 5 | 2 | 1 | 1 | **94.4%** |

**ТАНИЛЦСАН:**
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН ДАРГА С.ЭНХБАЯР

**ХЯНАСАН:**
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Б.МӨНХБАЯР

**ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:**
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН С.БОЛДОО

**БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:**
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ, ТАЙЛАН
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН М.ГАЧМАА